



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/10

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал"-аар хэрэгжүүлэх "Мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэн тарьц суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор хайгуул хийж гүн өрмийн худаг гаргаж, ус нөөцлөх сав суурилуулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Д.Батцэцэг

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Ц.Уранбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Т.Дашцэдэн

(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Т.Болдбаатар

(Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн)

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж эзэмшил ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ